



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Төвийн үйлчлүүлэгч иргэдийн түр
хоноглох байрны дотоод журмыг
шинэчлэх ажлын хэсэг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хүн амын хөгжил, Нийгмийн Хамгааллын сайдын 2012 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/51 дүгээр тушаалын хавсралт, төвийн дүрмийн дагуу төвийн даргын 2019 оны А/10 дугаартай тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 2.6, 2.8, 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төвийн үйлчлүүлэгч иргэдийн түр хоноглох байрны дотоод журмыг шинэчлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч

О.Пүрэвсүрэн (нийгмийн ажилтан)

Нарийн бичгийн дарга

Б.Буянсүрэн (сэтгэл зүйч)

Гишүүд

О.Насанбуян (нийгмийн ажилтан)

Б.Нандинцэцэг (ахлах нийгмийн ажилтан)

Б.Чинбат (байр хариуцсан нийгмийн ажилтан)

2. Үйлчлүүлэгч, албан хаагч нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийг судалж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Н.Нэргүй)-д үүрэг болгосугай.

3.Төвийн үйлчлүүлэгч иргэдийн түр хоноглох байрны дотоод журмыг 2024 оны 01 дүгээр сарын 22-ний өдөр даргын дэргэдэх зөвлөлд танилцуулсугай.

ДАРГА



Ш.МӨНХЦЭЦЭГ